



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 24

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд "Итгэлт тайж" ХХК-аар хийлгэсэн 8500.0 мянган төгрөгийн өртөг бүхий байр зүйн зургийг хөрөнгөд орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.




Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 8,500,000 /Найман сая таван зуун мянган/ төгрөгийн байр зүйн зургийг сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгөд орлогоор бүртгэж, 2018 оны эхний улирлын санхүүгийн тайланд залруулах.

2518011

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.05.01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бөмбөгөр сумын Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Ж.Гандалай нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹: 	Б.ДОЛЖМАА
	ЗӨВШӨӨРСӨН: B-0A0067 9007423	
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ		Д.МӨНХ-ЭРДЭНЭ
НЯГТЛАН БОДОГЧ		Ж.ГАНДАЛАЙ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 30

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Бөмбөгөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2017 онд худалдан авсан 400,0 мянган төгрөгийн өртөг бүхий зургийн аппаратыг хөрөнгөд орлого аваагүй.

2. Сум хөгжүүлэх сангаас 2013 онд олгосон 25572.9 мянга, 2014 онд олгосон 21932.0 мянга, 2015 онд олгосон 14706.6 мянга, 2016 онд олгосон 30126.6 мянга, нийт 92338.3 мянган төгрөгийн зээл, хүүгийн орлого зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүй, хугацаа хэтрүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн гэрээний холбогдох заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй", 4.1.5 "Байгуулсан гэрээ, хэлцэл, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**


2518019

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 400,000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийн зургийн аппаратыг сумын ЗДТГ-ын хөрөнгөд орлогоор бүртгэж, 2018 оны эхний улирлын санхүүгийн тайланд залруулах.

2. Сум хөгжүүлэх сангаас зээл авч, зээлийг хугацаандаа төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, зээлийг төлүүлэх арга хэмжээг авч, 2018 оны 06 дугаар сарын 20-ны дотор сумын Сум хөгжүүлэх сан дахь дансанд зээлийг төвлөрүүлэх.

3. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бөмбөгөр сумын Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Ж.Гандалай нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹: 	Б.ДОЛЖМАА
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ	ЗӨВШӨӨРСӨН: 	Д.МӨНХ-ЭРДЭНЭ
НЯГТЛАН БОДОГЧ		Ж.ГАНДАЛАЙ

0417-45544
Б.ДА0067 9007429

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 31

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Эм Би Би Импекс” ХХК-аас 4290.0 мянган төгрөгийн 429 боодол өвс авсан байхад 2090.0 мянган төгрөгийг шилжүүлж, өвсний үнэнд 2200.0 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй, тус аж ахуйн нэгжтэй тооцоо нийлсэн акт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна, гэснийг зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. “Эм Би Би Импекс” ХХК-тай тооцоо нийлж, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, 2018 оны эхний улирлын санхүүгийн тайланд залруулах

2518021

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.04.01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын ЗДТГ-ын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹: 	Б.ДОЛЖМАА
	ЗӨВШӨӨРСӨН: 	М.ЖАВЗАНСҮРЭН
	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ-ЫН	Б.ҮЛЭМЖСОНИН
ДАРГА		
НЯГТЛАН БОДОГЧ		

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.